


Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн
53 тоот тогтоолын хавсралт 1



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

“Худалдаа, хөгжлийн банкны Эрсдэлийн удирдлагын бодлого”-ын гарчиг

1. Нийтлэг үндэслэл
2. Эрсдэлийн удирдлагын хамрах хүрээ
3. Банкны эрсдэлийн засаглал
4. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл явц
5. Эрсдэлийн удирдлагын үндсэн зарчмууд
6. Хариуцлага

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Худалдаа, хөгжлийн банкны эрсдэлийн удирдлагын бодлого (цаашид **“Бодлого”** гэх)-ыг Монгол Улсын хууль тогтоомж, Монголбанкны бодлого, журам, заавар болон Олон улсын Базелийн хорооноос гаргасан зөвлөмжийн хүрээнд Худалдаа, хөгжлийн банк (цаашид **“Банк”** гэх)-ны дотоод үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, эрсдэлийн зохистой засаглал, хяналтын тогтолцоог нэвтрүүлэхэд шаардлагатай бодлогын асуудлыг нарийвчлан тодорхойлох чиглэлээр боловсруулсан ба эрсдэлийн удирдлагын чиглэлээр явуулах бүхий л үйл ажиллагаанд баримтлан ажиллана.
- 1.2. Энэхүү бодлогын зорилго нь банкны стратеги зорилтыг хэрэгжүүлэх, тогтвортой хөгжлийг хангахад туслалцаа үзүүлэхэд орших ба банкны үйл ажиллагаанд гарах алдагдал, эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах замаар банкны ашигт ажиллагааг дэмжихэд чиглэгдэнэ.
- 1.3. Энэхүү бодлогод хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. **“Эрсдэлийн удирдлагын хороо”** (цаашид **“ЭУХ”** гэх) гэж **“Худалдаа, хөгжлийн банкны Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам”**-д тодорхойлон заасныг;
 - 1.3.2. **“Эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын газар”** (цаашид **“ЭУБЗГ”** гэх) гэж банкны хэмжээнд зээл, харилцагч тал болон улс орны эрсдэл, зах зээлийн эрсдэл, хүүний эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, нэр хүндийн эрсдэл, стратегийн эрсдэлийн удирдлагын бодлого, дүрэм, журам, арга аргачлалыг тодорхойлох, батлуулах, эргэн хянах үүрэг бүхий Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид **“ТУЗ”** гэх)-өөс баталсан бүтцийн нэгжийг;
 - 1.3.3. **“Эрсдэл”** гэж тодорхойгүй байдлаас үүсэх хүсээгүй үр дүн буюу хүчин зүйлсийн нөлөөгөөр хэвийн үйл ажиллагаа алдагдах, орлогыг бууруулах, алдагдалд хүргэх нөхцөл байдлыг;
 - 1.3.4. **“Зээлийн эрсдэл”** гэж зээлдэгч чзээлийн гэрээний үүргийн дагуу зээл болон түүнтэй адилтгах активын үндсэн болон хүүний төлбөрөө төлж чадахгүй байх, эсвэл зээлээ төлөхийг хүсэхгүй байснаас үүсэх эрсдэлийг;
 - 1.3.5. **“Зах зээлийн эрсдэл”** гэж зах зээл дэх санхүүгийн хэрэгслийн үнийн хэлбэлзлээс учирч болох эрсдэлийг;
 - 1.3.6. **“Хөрвөх чадварын эрсдэл”** буюу **“Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл”** гэж банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй байх нөхцөлийг хангаж байгаа боловч харилцагчийн анхны шаардлагаар хүлээсэн үүргээ цаг тухайд нь биелүүлж чадахгүй болох, эсвэл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гаргах нөхцөл байдал үүсэх эрсдэлийг;
 - 1.3.7. **“Хүүний эрсдэл”** гэж хүүний хувь хэмжээний өөрчлөлтөөс үүдэн учирч болох эрсдэлийг;
 - 1.3.8. **“Харилцагч талын эрсдэл”** буюу **“Counterparty эрсдэл”** гэж гадаад, дотоодын зах зээл дээр санхүүгийн үйл ажиллагаа явуулахад тухайн харилцагч банкны эрсдэлтэй холбоотойгоор банканд учирч болох зээлийн эрсдэлийг;

- 1.3.9. **“Улс орны эрсдэл”** гэж олон улсын зах зээл дээр санхүүгийн үйл ажиллагаа явуулахад тухайн улсын эрсдэлтэй холбоотойгоор банканд учирч болох эрсдэлийг;
- 1.3.10. **“Стратегийн эрсдэл”** гэж зах зээлийн өрсөлдөөн, хууль эрх зүйн орчин, макро эдийн засгийн хүчин зүйлс, стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл зэргээс шалтгаалан банкны ашиг орлого нь төсөв, төлөвлөгөөгөөр хүлээгдэж буй зорилтот түвшинд хүрэхгүй байх эрсдэлийг;
- 1.3.11. **“Нэр хүндийн эрсдэл”** гэж банкны бренд, нэр хүндэд хохирол учирсны улмаас банкны ашигт ажиллагаа, төлбөрийн чадвар, хөрвөх чадварын болон бусад эрсдэлийг бий болгох эрсдэлийг;
- 1.3.12. **“Банкны эрсдэлийн аппетит”** гэж банкны стратеги зорилт, бизнесийн төлөвлөгөөн дээр үндэслэж ирээдүйд чиглэсэн байдлаар тодорхойлсон гол эрсдэлийн үзүүлэлтүүд болон тэдгээрийн лимитийг;
- 1.3.13. **“Эрсдэлийн удирдлагын тогтолцоо”** гэж банкны эрсдэлийн удирдлагын засаглал, соёл, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх бүх газар нэгжүүд, эрсдэлийн удирдлагатай холбоотой журам заавар, арга аргачлалуудыг тус тус ойлгоно.

ХОЁР. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГЫН ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Банк нь эрсдэлийн дараах үндсэн чиглэлүүдийг доорх байдлаар удирдана. Үүнд:
 - 2.1.1. **Зээлийн эрсдэл:** Зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд зээл олгохоос бүрэн төлөгдөж дуусах хүртэлх бүх шатанд гарах эрсдэлийг хамруулах бөгөөд банк нь зээлийн эрсдэл үүсч болох нөхцөл байдлыг тодорхойлсны үндсэн дээр зээлдэгчид тавигдах шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, олгогдсон зээлийг үнэлэх, эргэн хянах, эрсдэлийг бууруулах, зээлийн багцын эрсдэлийг боломжит бага түвшинд байлгахад чиглэгдсэн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, зээлийн эрсдэлийн түвшинг банкны удирдлагад тайлагнахад чиглэгдсэн цогц системийг хэрэгжүүлнэ.
 - 2.1.2. **Зах зээлийн эрсдэл:** Зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд валют, таваар, үнэт цаасны ханшийн өөрчлөлт, тэдгээрийн хоорондын хамаарлаас үүдэн банкны эзэмшиж буй санхүүгийн хэрэгслээс алдаж болох алдагдлыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг эрсдэлийн аппетит, лимитээр хязгаарлах, удирдах, хянах, банкны удирдлагад тогтмол тайлагнахад чиглэгдэнэ.
 - 2.1.3. **Хүүний эрсдэл:** Хүүний эрсдэлийн удирдлагын хүрээнд хүүний хувь хэмжээний өөрчлөлтөөс банкны ашигт ажиллагаа, орлогод учирч болох алдагдлыг үнэлэх, зохих аппетит, лимитийг тодорхойлох, хянах болон банкны удирдлагад тогтмол тайлагнахад чиглэгдэнэ.
 - 2.1.4. **Хөрвөх чадварын эрсдэл:** Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг тогтоосон лимитийн түвшинд хангах, зохистой хяналтыг хэрэгжүүлэх, банкны удирдлагад тогтмол тайлагнахад чиглэгдэнэ.
 - 2.1.5. **“Харилцагч талын эрсдэл”** буюу **“Counterparty эрсдэл”**: Гадаад, дотоодын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй банк, санхүүгийн байгууллагуудын эрсдэлийн үнэлэмжээс хамааруулан учирч болзошгүй эрсдэлд лимит тогтоох, эргэн хянах, тайлагнан ажиллахад чиглэгдэнэ.
 - 2.1.6. **“Стратегийн эрсдэл”**: Банкны стратегийн зорилгод хүрэхүйц банкны дунд хугацааны төсөв төлөвлөгөөг боловсруулан батлуулж уг төсөв төлөвлөгөөний гүйцэтгэлд тухай бүр хяналт тавих, тайлагнах, биелэлтийг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

2.1.7. “Нэр хүндийн эрсдэл”: Банкны талаар олон нийт болон харилцагч, үйлчлүүлэгчдийн дунд бий болсон сөрөг мэдээллийг илрүүлэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах болон банкны үйл ажиллагаанд нөлөөлөхүйц ноцтой нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ.

2.2. Банк нь эрсдэлийн дээрх үндсэн чиглэлүүдээр газар, хэлтэс, нэгжүүдийн үүрэг оролцоог заасан эрсдэлийн удирдлагыг нарийвчлан зохицуулах бодлого, заавар, журмын аль нэгэнтэй байх бөгөөд тэдгээр нь энэхүү бодлоготой нийцтэй байна.

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

3.1. Банкны эрсдэлийн удирдлага нь дараах дарааллын дагуу хэрэгжинэ. Үүнд:

3.1.1. **Эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох** - зээл олгох, бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, хэлцэл хийх зэрэг аливаа үйл ажиллагаатай холбоотой үүсч болзошгүй эрсдэлийг илрүүлж, ангилах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.1.2. **Эрсдэлийг үнэлэх** - эрсдэл үүсэх магадлалыг шинжилж үнэлгээ өгөх, тодорхой төрлийн эрсдэл үүссэний улмаас гарч болзошгүй алдагдлын хэмжээг тооцох буюу банкны хүлээж болзошгүй эрсдэлийн нийт хэмжээг тодорхойлж үнэлгээ өгөх;

3.1.3. **Эрсдэлийг бууруулах** - эрсдэл үүсэх магадлалыг бууруулах, үүссэн эрсдэлийн улмаас хүлээх алдагдлын хэмжээг хамгийн бага түвшинд буюу хүлээн зөвшөөрөхүйц түвшинд байлгах боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.1.4. **Эрсдэлийг хянах** - банкны хүлээн зөвшөөрч болохгүй эрсдэлүүд, түүнд гарсан өөрчлөлтүүдийг тогтмол хянах, лимитийн хүрээнд эсэхийг тодорхойлох;

3.1.5. **Эрсдэлийг тайлагнах** - эрсдэлийн тайлан мэдээ, үнэлгээний үр дүн, дүгнэлт, лимитүүдийн биелэлтийг банкны удирдлагад тайлагнахыг;

3.2. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх газар, хэлтэс, нэгжүүдийг дараах байдлаар ангилна. Үүнд:

3.2.1 **Нэгдүгээр шугамын хамгаалалт** – Бизнесийн нэгжүүд болох эрсдэлийг бий болгох, хүлээн авах газар нэгжүүд (Байгууллагын банкны газар, Жижиг дунд бизнесийн банкны газар, Салбар тооцооны төвүүд, Хөрөнгө зохицуулалтын газар гэх мэт)

3.2.2 **Хоёрдугаар шугамын хамгаалалт** – Эрсдэлийн удирдлагыг бизнесийн нэгжүүдээс хараат бусаар хэрэгжүүлэх газар нэгжүүд (ЭУБЗГ, Зээлийн эрсдэлийн газар, Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын газар гэх мэт)

3.2.3 **Гуравдугаар шугамын хамгаалалт** – Дотоод аудитын газар

ДӨРӨВ. БАНКНЫ ЭРСДЭЛИЙН ЗАСАГЛАЛ

4.1. Банкны ТУЗ, Эрсдэлийн удирдлагын хороо, гүйцэтгэх удирдлага, газар, хэлтэс, нэгжүүдийн эрсдэлийн удирдлага дахь үүрэг оролцоог дараах байдлаар зохицуулна. Үүнд:

4.1.1. ТУЗ нь:

4.1.1.а. ЭУХ болон эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх газар, хэлтэс, нэгжүүд, тэдгээрийн бүтэц зохион байгуулалтыг батлах;

4.1.1.б. Банкны эрсдэлийн аппетитыг батлах;

4.1.1.в. Банкны эрсдэлийн удирдлагын бодлогыг батлах;

4.1.1.г. Эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, эрсдэлийн засаглал, соёлын тогтолцоо нь зохистой эсэхэд хяналт тавих;

4.1.1.д. Банкны стратеги, төлөвлөгөөг батлах;

4.1.1.е. Банканд учирч буй гол эрсдэлийн талаар мэдээлэлтэй байх.

4.1.2. ЭУХ нь:

4.1.2.а. Банкны эрсдэлийн аппетитыг хэлэлцэх, хэрэгжилтэд хяналт тавих;

4.1.2.б. Банкны эрсдэлийн удирдлагын бодлогыг хэлэлцэх, хэрэгжилтэд хяналт тавих;

4.1.2.в. Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоог хараат бус, оновчтой, зохистой эсэхэд хяналт тавих;

4.1.2.г. Банканд учирч буй гол эрсдэлийн талаар ТУЗ-д тайлагнах;

4.1.2.д. Эрсдэлийн соёлыг түгээн дэлгэрүүлэх;

4.1.2.е. Эрсдэлийн арга аргачлалуудтай танилцсан байх, сайжруулах зөвлөмж гаргах.

4.1.3. Эрсдэл Хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч нь:

4.1.3.а. Банкны эрсдэлийн засаглал, тогтолцоо нь ТУЗ-ийн баталсан бүтцийн дагуу оновчтой эсэхэд хяналт тавих;

4.1.3.б. ЭУХ болон ТУЗ-д банкны аливаа эрсдэл, лимитүүдийн биелэлтийн талаар хараат бусаар тайлагнах;

4.1.3.в. Эрсдэлийн соёлыг түгээн дэлгэрүүлэх;

4.1.3.г. Эрсдэлийн хоёрдугаар хамгаалалтын шугамын газар, нэгжүүдийг удирдлагаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавих;

4.1.3.д. ЭУХ-ны гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих.

4.1.4. Банкны удирдлага, удирдлагын түвшний хороод (Удирдлагын хороо, Актив, пассивын хороо, Зээлийн хороо гэх мэт) нь:

4.1.4.а. ТУЗ-өөс тогтоосон эрсдэлийн аппетит, бодлогыг мөрдөн ажиллах;

4.1.4.б. Эрсдэлийн аппетит, бодлоготой уялдуулан эрсдэлийн холбогдох лимитүүдийг батлах, мөрдөх;

4.1.4.в. Эрсдэлийн арга аргачлалыг батлах;

4.1.4.г. Эрсдэлийн түвшин нь холбогдох лимитүүдээс хэтэрсэн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцэх, батлах.

4.1.5. Нэгдүгээр шугамын хамгаалалтад хамаарах газар хэлтэс, нэгж:

4.1.5.а. Эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох, шаардлагатай тохиолдолд хоёрдугаар шугамын хамгаалалтын газар, хэлтэс, нэгжүүдээр тодорхойлуулах, үнэлүүлэх;

4.1.5.б. Эрсдэлийг таних, үнэлэх, хянах үйл ажиллагаанд нь хоёрдугаар шугамын хамгаалалтын газар, хэлтэс, нэгжүүдийг үнэн бодит мэдээллээр хангах;

4.1.5.в. Эрсдэлийг батлагдсан лимит, эрхийн хүрээнд бууруулахад чиглэгдсэн бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

4.1.5.г. Батлагдсан эрсдэлийн аппетит, лимит, шалгуур үзүүлэлтүүдийг мөрдөж ажиллах;

4.1.5.д. Хоёрдугаар шугамын хамгаалалтын газар, хэлтэс, нэгж болон банкны удирдлагыг шинээр илэрсэн болон үүсч болзошгүй эрсдэлийн талаарх мэдээллээр цаг алдалгүй хангах.

4.1.6. Хоёрдугаар шугамын хамгаалалтад хамаарах газар, хэлтэс, нэгж:

4.1.6.а. Эрсдэлийн аппетит, лимитүүд, арга аргачлал, журам зааврыг холбогдох газар, хэлтэс, нэгжүүдтэй хамтран боловсруулах, батлуулах;

4.1.6.б. Эрсдэлийг үнэлэх, хяналт, тайлагналыг хэрэгжүүлэх;

4.1.6.в. Эрсдэлийн лимитийг мөрдөх, бууруулах талаар бусад газар, хэлтэс, нэгжүүдэд зөвлөмж өгөх;

4.1.6.г. Банкны эрсдэл нь холбогдох лимитүүдийн хүрээнд байгаа эсэхэд хяналт тавих;

4.1.6.д ЭУХ-нд эрсдэлийн арга аргачлалууд, тэдгээрийн буцаан шалгалтын талаар тайлагнах.

4.1.7. Гуравдугаар шугамын хамгаалалтад хамаарах газар, хэлтэс, нэгж:

4.1.7.а. Эрсдэлийн удирдлагын бодлого, заавар, журмын биелэлт, үр дүн, банкны хүлээх эрсдэлд тогтоосон хязгаарлалтыг баримталж байгаа эсэхэд баталгаажуулалт хийж, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгч ажиллана.

ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ҮНДСЭН ЗАРЧМУУД

5.1. Банк нь эрсдэлийн удирдлагын тогтолцоондоо дараах зарчмуудыг мөрдлөг болгоно. Үүнд:

5.1.1. *Банкны бүхий л үйл ажиллагааны салшгүй хэсэг байх.* Банкны бүхий л үйл ажиллагааг эрсдэлийн удирдлагаар хангана.

5.1.2. *Шийдвэр гаргах үйл явцын нэг хэсэг байх.* Банкны удирдлага болон бизнесийн нэгжүүдийн шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлнэ.

5.1.3. *Тодорхой бус байдлыг ил тод байлгах.* Аливаа тодорхойгүй байдлыг илрүүлж, тэдгээрээс үүсч болзошгүй эрсдэлээс сэргийлнэ.

5.1.4. *Хараат бус, бие даасан байх.* Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ хараат бус, хөндлөнгийн байр суурьнаас үнэлж, дүгнэн, тайлагнана.

5.1.5. *Боломжит мэдээлэлд үндэслэсэн байх.* Эрсдэлийн удирдлагад түүхэн баримт мэдээлэл, бусад газар нэгжийн санал, ажиглалт, урьдчилсан таамаг болон эрсдэлийн ажилтны дүгнэлт зэрэг бодит мэдээллийг үндэслэнэ.

5.1.6. *Онцлог нөхцөл байдалд тохирсон байх.* Гадаад болон дотоод нөхцөл байдалд тохируулан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

5.1.7. *Мэдлэг ур чадварыг тасралтгүй хөгжүүлдэг байх.* Эрсдэлийн удирдлагын хүрээнд ажиллах ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэхэд чиглэгдсэн сургалтын хөтөлбөрүүдтэй байх ба ажилтнуудаас мэргэжлийн ёс зүй, дүрэм журам, стандартыг сахин ажиллахыг шаардах;

5.1.8. *Ил тод ба оролцоог хангасан байх.* Банкны газар нэгжүүд болон бусад оролцогч талуудтай мэдээлэл солилцон, зөвлөлдөж, санал зөвлөмжийг тусгана.

5.1.9. *Тогтмол сайжруулалтыг хийж байх.* Тогтмол хугацааны давтамжтайгаар эрсдэлийн удирдлагын тогтолцоондоо эргэн хяналт хийх, шаардлагатай өөрчлөлт сайжруулалтыг тухай бүр хийнэ.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Бодлогыг зөрчсөн ажилтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй бол Банк хууль хяналтын байгууллагад хандаж шалгуулна.

- 6.2. Бодлогыг зөрчсөн холбогдох ажилтны үйлдэл, эс үйлдэхүйд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага, шийтгэл оногдуулсан эсэхээс үл хамааран Банк Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Банкны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.
- 6.3. Бодлогыг зөрчсөн ажилтны үйлдэл, эс үйлдэхүй нь Банкны болон харилцагчийн эд хөрөнгөнд хохирол учруулсан бол түүнд сахилгын, эрүүгийн хариуцлага, түүнчлэн Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл ногдуулсан эсэхээс үл хамааран Банк эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэнэ.
- 6.4. Бодлогыг зөрчсөн ажилтны үйлдэл, эс үйлдэхүй нь Банкны ажил хэргийн нэр хүндэд гэм хор учруулсан бол уг гэм хорыг тухайн ажилтан хариуцан арилгана.

--- оо0оо ---